

С.Гомбо

*МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш
Социологийн ухааны доктор (PhD), профессор*

ЗАРИМ ХОТУУДЫН ХҮН АМЫН ЦАГ АШИГЛАЛТЫН НИЙТЛЭГ БА ОНЦЛОГ

Цагийн төсвийн ашиглалт нь хүмүүсийн өдөр тутмын амьдрал үйл ажиллагааг тухайлбал, ажил хөдөлмөр эрхлэх болон аж байдал, чөлөөт цагийн ашиглалт, тэдний төрөл бүрийн хэрэгцээг хангах ажлын зохион байгуулалт, улмаар хүн амын амьдралын түвшин зэргийг тусгаж байдаг.

Ийм учраас хүн амын цаг ашиглалт нь тухайн орны үйлдвэрлэх хүчний хөгжлийн түвшин, ажил, амьдрал, амралтын нөхцөл, үндэсний соёл, зан заншлын онцлог зэргээс ихээхэн хамааралтай. Эдгээр онцлогийг судлан илрүүлэх нь хүн амын хөдөлмөр, аж байдал, амралт, чөлөөт цагийн ашиглалтын түвшинг ойртуулах боломжийг хангахад онцгой ач холбогдолтой юм.

Монгол Оросын хооронд хийгдсэн анхны харьцуулсан судалгаа нь хотуудын оршин суугчдын цаг ашиглалтын нийтлэг ба онцлог, ялгаатай байдал болон улмаар тэдний цаг ашиглалтыг сайжруулах үндсэн чиглэлийг тодруулах зорилготой байсан юм.

Ийм учраас байгаль, цаг уур, газар нутгийн хувьд ойролцоо түвшний хотуудын хүн амыг судлах шаардлагатайг харгалзан ОХУ-аас хүн амын үндсэн хэсэг нь Буриадууд амьдардаг Улаан-Үд болон Казах ССР-ийн томоохон хотын нэг Карагандад манайхаас түлш эрчим хүч, хөнгөн хүнсний аж үйлдвэрийн гол хотын нэг болох Дархан хотыг судалгааны объект болгон сонгосон. Уг судалгааг Карагандад 1987 оны сүүлээр, Улаан-Үдэд 1988 оны эхээр, Дарханд 1988 оны намар тус тус хийсэн юм.

Эдгээр судалгааны түүврийг 18-аас дээш насны /ажил эрхэлдэг ба ажилгүй/ хүмүүсээс бүрдүүлсэн. Үүнээс гадна манай орны хувьд 1988 онд Булган аймгийн төвд болон түүнээс арай эрт 1983 онд Улаанбаатар хотын 6 үйлдвэрт хийгдсэн судалгааны баримтуудыг энэ өгүүлэлд ашиглав. Энэ бүх судалгаанууд ЗХУ-ын (хуучин нэрээр) ШУА-ын Социологийн хүрээлэнгийн ажлын ба ажлын бус цагийн секторт боловсруулсан нэг арга зүйн дагуу хийгдсэн юм. Хэдийгээр цаг хугацааны хувьд нэгэн зэрэг хийгдээгүй ч гэсэн дээрх хотуудын цагийн төсвийн ерөнхий ба зарим онцлогийг харьцуулан үзэх боломжтой.

Учир нь түүвэр хийх, мэдээлэл авах, боловсруулах ажиллагаа нэгдсэн нэг л арга зүй, аргачлалаар хийгдсэн болно.¹

Хүснэгт-1

**Хотуудын 18-аас дээш насны хүн амын
цаг ашиглалтын бүтэц /хувиар/**

№		Дархан /1988 он/	Улаан-Үд /1988 он/	Караганда /1987 он/
	Судлагдсан хүний тоо	1030	675	2855
1	Ажлын ба түүнтэй шууд холбоотой үйл ажиллагаа	28,9	21,9	23,1
2	Ахуйн хэрэгцээг хангах ба гэр орны ажил	16,7	16,4	14,5
3	Физиологийн хэрэгцээг хангах үйл ажиллагаа	39,5	42,0	41,3
4	Чөлөөт цагийн үйл ажиллагаа	14,9	19,7	21,1
	ДҮН	100,0	100,0	100,0

Хүснэгт-1-ээс харахад дээрх хотуудын хүн амын амьдрал үйл ажиллагааны үндсэн дөрвөн төрлийн хувьд цалинтай ажил түүнтэй холбоотой үйл ажиллагааны болон чөлөөт цагийн хэмжээ

¹ Цагийн зарцуулалтын мэдээлэл авахдаа судалгаанд хамрагдсан бүх хүн гэхэд л өглөө боссоноос хойш унтах хүртлээ цагийн дарааллаар хийж гүйцэтгэсэн бүхий л үйл ажиллагааны төрөл хэлбэрээ түүнд зарцуулсан цаг хугацааны хамт нэгд нэгэнгүй бичсэн хронологийг хөтлөдөг

МУИС Нийгмийн шинжлэх ухааны сургууль

эрс ялгаатай байна. Энэ нь манайд тэр үед хуулиар тогтоогдсон ажлын цагийн хэмжээ их байсантай холбоотойгоор чөлөөт цаг нь бусдаас бага байна. (Улаан-Үд, Карагандад чөлөөт цаг нь долоо хоногийн цагийн нийт төсвийн 19,7-21,1%-ийг эзэлж байхад Дарханд дөнгөж 14,9% байна.)

Өөрөөр хэлбэл, Дархан хотын 18-аас дээш насны нэг хүн долоо хоногт дунджаар 25 цагийн чөлөөт цагтай байхад энэ үзүүлэлт Улаан-Үдэд 33 цаг, Карагандад 35 цаг байна гэсэн үг юм.

Судалгаанд ажил эрхэлдэг ба ажилгүй хүмүүсийг дээрх хотуудын хувьд дүйцүүлж (ойролцоо пропорциор) хамруулсан ч гэсэн долоо хоногийн ажлын цаг Орост 42 цаг, манайд 46 цаг байснаас шууд хамаарч энэ ялгаа гарч байгаа нь хэн бүхэнд ойлгомжтой. (Ажилгүй хүмүүсээс ажил эрхэлдэг хүмүүс хэд дахин олон хүмүүс хамрагдсан.)

Гэхдээ нөгөө талаар нийгэм ахуй хангамжийн түвшний ялгаатай байдал дээрх хотуудын хүн амын цаг ашиглалтын онцлог ялгааг нөхцөлдүүлж байгаа юм. Тухайлбал, орон сууцны хангамж, нийтийн тээврийн болон ахуйн үйлчилгээний түвшин зэргээс хамаарч гэр орны ажлын цагийн ачаалал өөрчлөгддөг.

Судалгааны баримтаас үзэхэд гэр орны ажилд Дарханчууд дунджаар долоо хоногт 28 цаг зарцуулж байхад нөгөө хоёр (Улаан-Үд, Карагандад) хотынхны хувьд 24,3-27,5 цаг байв.

Нийт ажил хөдөлмөрийн ачаалал Дарханы эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувьд ойролцоогоор өдөрт 10,7-11,6 цаг, долоо хоногт 75,1-81,6 цаг байхад, Улаан-Үдэд эрэгтэйчүүд нь 67,7 цаг, эмэгтэйчүүд 73,0 цаг зарцуулж байлаа. Энд ажиглагдаж буй өөр нэгэн онцлог бол Монголын (Дарханы) эрэгтэйчүүд нөгөө хотын эрэгтэйчүүдээс илүү цаг зарцуулж байгаагаар илэрч байна. Гэр ахуйн ажилд Карагандын эрэгтэйчүүд долоо хоногт дунджаар 13,4 цаг зарцуулдаг байхад манайд энэ үзүүлэлт 18,7 цаг байв. (Хүснэгт-2)¹

Энэ нь орон сууцны хангамжийн түвшин манайд харьцангуй доогуур тэдний нилээд нь гэр хашаанд амьдардаг учраас ус, нүүрс түлээ бэлтгэх, хашааны хог шороо цэвэрлэх, тээвэрлэх гээд эрэгтэй хүний хүч шаардах ажил давамгайлдагтай холбоотой юм.

Хүснэгт -2

Хотуудын ажил эрхэлдэг хүн амын цагийн төсвийн ашиглалт (долоо хоногийн нэг өдөрт дунджаар нэг хүнд ноогдох минутаар)

№		Эрэгтэй			Эмэгтэй		
		Караганда	Улаан-Үд	Дархан	Караганда	Улаан-Үд	Дархан
	Хүний тоо	926	220	440	1100	317	454
1	Ажлын цаг	387,4	360,9	407,7	354,1	317,4	372,2
2	Ажилтай холбоотой үйл ажиллагааны цаг Үүнээс ажилдаа очиж, ирэхэд	99,0	73,1	76,6	67,0	852,7	70,6
		72,8	44,7	52,3	52,3	35,2	44,1
3	Ахуйн хэрэгцээг хангах ба гэр орны ажил 1-3-ын дүн /нийт хөдөлмөрийн ачаалал/	115,2	146,2	160,0	236,3	255,3	256,7
		601,6	580,2	644,3	657,4	625,4	699,5
4	Физиологийн хэрэгцээг хангах	276,5	587,9	574,6	576,3	593,8	553,3
5	Чөлөөт цаг	260,8	271,3	220,9	206,3	220,0	185,0
6	Бусад	1,1	0,6	0,2	-	0,7	2,2
	БҮГД	1440	1440	1440	1440	1440	1440

Өөр нэгэн онцлох зүйлд ажил эрхэлдэг хүмүүсийн цагийн төсвийн ашиглалт манайд томоохон хот (Улаанбаатар), дунд зэргийн хот (Дархан), бага хот (Булган)-ынхны хувьд мэдэгдэхүйц ялгаатай байгааг дурьдах ёстой.

Юуны өмнө энэ нь ажилтай шууд холбоотой цаг Улаанбаатар Дарханчуудаас Булганд бага, харин гэр орны ажилд тэднээс их хугацаа зарцуулж байгаагаар илэрч байна. (Хүснэгт-3)

¹ Хүснэгт 2 өдөрт нэг хүнд ногдож байгаа минутыг 60-д хуваагаад, 7-оор үржүүлж долоо хоногт ногдох нийт цагийг гаргана.

Жишээлбэл, гэр орны ажилд Улаанбаатар хотынхноос Дарханыхан долоо хоногт 1,4-2,5 цагаар, Булганыхан 3,9-5,8 цагаар тус тус илүү хугацаа зарцуулдаг байна.

Цагийн төсвийн судалгаагаар гэр орны ажилд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээсээ илүүтэй оролцдог баримт маш ховор байдаг.

Улаанбаатар хотын аж үйлдэрт ажиллагсдыг бодвол Дарханаас, ялангуяа Булганаас судалгаанд хамрагдагсдын дунд энгийн галлагаатай байшин, гэрт суудаг хүмүүс дийлэнх болж байгаагаас дээр дурьдсанчлан хашаа хороогоо цэвэрлэх, ус түлээ түлшээ авах гээд гэрийн гадуурх ажилд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүүтэй оролцох шаардлага гардагтай холбоотой байна.

Энэ ажилд Булганд хийгдсэн судалгаагаар долоо хоногт дунджаар эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээсээ 3,4 дахин их буюу 6,8 цаг зарцуулж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт Дарханд 2,3 дахин их буюу 3 цаг байна.

Харин хотынхны баримтаар бол энэ ажилд долоо хоногт нэг л цаг зарцуулдаг үзүүлэлт гарчээ. Гэрийн гадуурх эдгээр ажилд хотын эрэгтэйчүүдээс Дарханы эрэгтэйчүүд 3 дахин, Булганы эрэгтэйчүүд 6 дахин их цаг зарцуулдаг байна гэсэн үг юм.

Энэ нь Улаанбаатар хотынхны (судалгаанд хамрагдсан хүмүүсийн) хувьд хашаанд амьдардаг хүмүүс тал хувь нь байгаатай холбогдох боловч хөдөөгийнхнийг бодвол хашаа хороондоо цэвэр цэмцгэр, соёлтой амьдрахын тулд тэд нар цаг гаргаж санаа тавих санаачлага хангалтгүй байдагтай ч холбоотой гэж үзэх үндэслэлтэй.

Гэрийн гадуурх ажилд ийм ялгаа байгаа ч гэсэн гэр орны дотоод ажил хоол унд хийх, хувцас хунар, аяга таваг угаах, цэвэрлэгээ хийх гэх мэт ажилд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээсээ 2 дахин их цаг зарцуулдаг нийтлэг байдал аль ч хотынхны хувьд ижил байна.

Үр хүүхдээ асрах, хүмүүжүүлэхэд тавих анхаарал халамжийн хувьд Улаанбаатар хотынхныг бодвол Дархан, Булганыхан мөн эмэгтэйчүүд нь илүү цаг зарцуулдаг байна. Энэ үзүүлэлт Улаанбаатар хотод эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд ойролцоо 3,0-3,4 цаг зарцуулж байхад Дарханд 4,2-7,0, Булганд 3,2-6,5 байна. (Хүснэгт-3)

Худалдаа үйлчилгээний газарт зарцуулж байгаа хугацаагаар Улаанбаатар болон Булганыхны хооронд онцын ялгаа алга, харин Дарханыхан долоо хоногт 1-3 цагаар илүү цаг зарцуулдаг ялгаа харагдаж байна. (Хүснэгт-3)

Эдгээр хотуудын хүн амын физиологийн хэрэгцээг хангах үйл ажиллагаанд зарцуулж буй хугацаа ерөнхийдөө ойролцоо байгаа нийтлэг ажиглагдана. Эдгээр хотуудын хүн амын чөлөөт цагийн ерөнхий хэмжээнд зарчмын ялгаатай байдал мөн харагдахгүй байна.

Харин эрэгтэй эмэгтэйчүүдийн чөлөөт цагийн ялгаа Улаанбаатарынхны хувьд арай их (5 цаг), харин энэ ялгаа Дарханд (4 цаг), Булганд (1цаг) бага байгаа онцлог илэрхий харагдаж байна.

Чөлөөт цагаа өнгөрүүлэх үйл ажиллагааны хэлбэрүүдийн бүтэц, дарааллын хувьд ялгаа бага байна. Аль ч хотуудын хүн амын чөлөөт цагийн ихэнх (ойролцоогоор 40-50 гаруй) хувийг (телевиз үзэх, сонин сэтгүүл унших гм) олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй харьцах, дараа нь айлаар орох, ах дүү найз нөхөдтэй харьцах, нийгэм олон нийтийн ажилд оролцох, үзвэр үзэх зэрэг үйл ажиллагаа эзэлж байна. (Хүснэгт-3)

Мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд Улаанбаатар хотынхныг бодвол хөдөөгийнхөн харьцангуй бага хугацаа зарцуулдаг байна. Соёл урлагийн байгууллага хотыг бодвол хөдөөд харьцангуй цөөн байдаг ч гэсэн тэд үзвэр үзэхэд хотынхноос дутуугүй цаг зарцуулдаг онцлог харагдаж байна. (Хүснэгт-3)

Улаанбаатар, Дархан, Булган хотоос судалгаанд хамрагдагсдын зарим үзүүлэлтийг Орост хийгдсэн судалгаатай харьцуулбал юуны өмнө чөлөөт цагийн хэмжээгээрээ эрс ялгаатай байгаа талаар өмнө цухас дурьдсан билээ.

Уг ялгааг (хүйсээр) эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд онцолж үзвэл Дархан хотын эрэгтэйчүүдийн чөлөөт цаг Псков хотын эрэгтэйчүүдийнхээс долоо хоногт 8,7 цагаар, Улаан-Үдийнхнээс бараг 6 дахин бага байх жишээтэй. Энэ үзүүлэлт эмэгтэйчүүдийн хувьд 4,9:4,0 цаг байна.

Харин чөлөөт цагийн хэмжээний талаарх сэтгэл ханамжийн үнэлэлт эрэгтэйчүүдийн хувьд ижил, эмэгтэйчүүдэд бага зэрэг ялгаатай байна. Сэтгэл ханамжийн түвшинг 5 баллын үнэлгээгээр тооцоолоход Псков, Дарханы эрэгтэй ажиллагсад ижилхэн 3,39, Дарханы эмэгтэйчүүд Псковынхноос арай дээгүүр үнэлгээ өгчээ. (Псков – 2,87, Дархан – 3,30 байв.)

Дарханы оршин суугчид боловсрол мэргэжлээ дээшлүүлэхэд Оросын хотынхоос харьцангуй бага хугацаа зарцуулдаг атлаа янз бүрийн нийгмийн ажилд арай илүү цаг гаргадаг ялгаа байгаа нь тэр үед (судалгаа хийсэн) манайд үйлдвэр аж ахуй, албан байгууллагуудад долоо хоногт тогтмол лекц, улс төрийн дугуйлан, сонсгол байнга зохиогддог байсантай холбоотой юм.

**Хотуудын хүн амын цагийн төсвийн ашиглалт
/долоо хоногт нэг хүнд ногдох цагаар/**

№	Судлагдсан хүний тоо	Улаанбаатар		Дархан		Булган	
		Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
1	Ажлын болон түүнтэй холбогдох нийт цаг.	58,5	58,1	56,5	51,7	51,3	46,7
	➤ Үүнд: Ажлын үндсэн цаг	47,4	46,9	47,6	43,4	45,9	41,6
	➤ Замд явсан болон бэлтгэл хангах	11,1	11,2	8,9	8,3	5,4	5,1
2	Гэр аж ахуйн ажил	8,8	14,0	10,2	16,5	14,6	17,9
	➤ Үүнд: гэр орны ажил	7,7	13,0	7,2	14,7	7,8	15,9
	➤ Гэрийн гадуурх ажил	1,1	1,0	3,0	1,8	6,8	2,0
3	Үр хүүхдээ асарч хүмүүжүүлэх	3,0	3,4	4,2	7,0	3,2	6,5
	➤ Үүнд: Хүүхэд асрах	1,2	1,7	2,8	5,4	2,4	5,3
	➤ Хүүхдээ хүмүүжүүлэх	1,8	1,7	1,4	1,6	0,8	1,2
4	Худалдаа, үйлчилгээнд	3,2	3,0	4,2	6,5	3,0	3,8
	➤ Үүнд: Худалдааны газарт	3,1	2,9	3,2	5,5	2,3	2,6
	➤ Ахуйн үйлчилгээнд	0,1	0,1	1,0	1,0	0,7	1,2
5	Физиологийн хэрэгцээ хангах	68,4	68,6	67,0	64,5	70,0	68,3
	➤ Үүнд: Өөрийгөө болон гэр бүлийнхнээ арчлахад	5,0	5,9	4,9	5,4	4,7	6,3
	➤ Хооллоход	10,7	10,0	9,6	8,6	10,9	9,0
	➤ Унтах	52,7	52,7	52,5	50,5	54,4	53,0
6	Чөлөөт цаг	25,8	20,6	25,8	21,6	24,5	23,4
	➤ Үүнд: Боловсрол мэдлэгээ дээшлүүлэх	2,2	1,8	0,8	0,7	0,2	0,1
	➤ Нийгэм, олон нийтийн ажил	1,1	1,1	3,5	2,0	3,1	2,5
	➤ Үзвэр үзэхэд	1,3	1,2	1,7	1,8	1,4	3,4
	➤ Айлаар орох, ах дүү танил найз нөхөдтэйгээ харьцах	3,5	2,7	2,6	2,4	4,1	1,1
	➤ Биеийн тамир спортын арга хэмжээн хамрагдах	1,0	0,5	0,8	0,6	1,0	0,4
	➤ Зугаалах, эрүүл агаарт явах	0,6	0,6	1,4	1,8	1,8	2,6
	➤ Сонирхдог зүйлээ хийх	0,2	0,4	0,4	1,0	0,1	2,1
	➤ Мэдээлэл авах /ТВ,радио, сонин, сэтгүүл гм./	13,8	10,6	12,4	9,5	11,2	9,8
➤ Идэвхгүй амралт	2,1	2,2	1,9	1,8	1,6	1,4	
7	Бусад	0,3	0,3	0,1	0,2	1,4	1,4
	Бүгд	168,0	168,0	168,0	168,0	168,0	168,0

Зорилгогүй, онцлон бүтээсэн зүйлгүй өнгөрөөж байгаа цаг ямар байх нь чөлөөт цагийн соёлын нэг үзүүлэлт байдаг. Чөлөөт цагийн ашиглалтанд энэ үйл ажиллагааны эзлэх хувийн жин Дархан, Улаан-Үд, Караганда хотынхны хувьд ялгаа бага байна. Идэвхгүй амралтын эзлэх хувь эрэгтэйчүүдэд ялимгүй илүү байгаа онцлог ажиглагдаж байгаа юм.

Эдгээр хотынхон чөлөөт цагийнхаа ихэнх хэсгийг гэр орондоо өнгөрүүлдэг ч гэсэн түүндээ бүрэн дүүрэн сэтгэл ханамжтай биш байдаг байна. Хэдийгээр чөлөөт цагийн хэмжээгээрээ ялгаатай ч гэсэн Монгол Оросын эдгээр хотын судалгаанд хамрагсад өөрсдийн хүссэнээрээ гэртээ амрахад юу саад болдог талаар дурьдсан шалтгаан нь ойролцоо байна.

Тухайлбал Псков, Карагандынхан ажлын дараа их ядардаг, амрах цаг бага, орон байрны болон соёлын хэрэгсэл дутмаг гэж ихэнх нь хариулсан байхад Дарханыхан мөн л амралтын соёл ахуйн хэрэгсэл дутагдалтай, ажлаасаа ядарсан байдаг, амралтын цаг хүрэлцээтэй биш, чөлөөт цагаа үр ашигтай өнгөрөөх чадвар хангалтгүй зэрэг шалтгаануудыг дурьдсан байна.

Манайд ажлын цаг их, чөлөөт цаг багатай атлаа түүнийг ашиглаж байгаа байдалдаа өгсөн сэтгэл ханамжийн түвшингээр Оросуудынхаас нам биш байгаа нь цагийг үр ашигтай өнгөрүүлэх соёлын ерөнхий түвшин, хэрэгцээ, шаардлага сул байдагтай холбоотой юм.

Ажлын цаг, чөлөөт цагийн харьцааг ямар байхыг хүсдэг вэ? гэсэн асуултанд Псков хотын судалгаанд хамрагсдын хоёр хүний нэг нь ажлын цаг бага, чөлөөт цаг ихтэй байхыг эрхэмлэдэг байхад Дарханыхны гурван хүний нэг л ийм санал гаргасан байх бөгөөд манайхны 40 гаруй хувь нь тухайн үеийн ажлын цагийг хэвээр байлгахыг хүсч байжээ.

Чөлөөт цагийг өнгөрүүлэх соёлын түвшин гэдэг ойлголт юу юуны өмнө цаг хугацааны үнэ цэнийг мэдэрч, аливаа ажлыг хойш тавихгүйгээр үр ашигтай ашиглах хувь хүний чадвартай шууд холбоотой байдаг. Чөлөөт цаг гэхээрээ зугаа цэнгэл, найр наадмыг голлох биш харин амьдрал ахуйдаа шаардагдах ажил, мэргэжлийн мэдлэг, оюуны чадамжаа дээшлүүлэхэд зорилго чиглэлтэй түүнийг ашиглахыг эрхэмлэх ёстой юм.

Энэ утгаар нь чөлөөт цагийг нийгмийн гишүүдийн мэдлэг чадвартай, эрүүл чийрэг бие бялдартай, өндөр соёл боловсролтой иргэн болж төлөвших орон зай нь гэж үзэж болно.

Ийнхүү хотуудын хүн амын цагийн төсвийн судалгааны баримтаар цаг ашиглалтын байдлыг товч ч гэсэн гаргаж байгаа нь эдүгээ болон хойшид ч гэсэн энэ төрлийн судалгааг сонирхон хийх хүмүүст харьцуулалт хийх боломжийг олгох болов уу гэж бодож байна.